



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/974

Мандалговь

Архи согтууруулах ундаа худалдан
борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт байрших Сүм хөх бүрд жуулчны баазад архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. “Сүм хөх бүрд” жуулчны баазын архи,согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰ -24⁰⁰ цаг хүртэл хугацаагаар баталсугай.

3. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Адаацаг сумын Засаг дарга (Ч.Уранчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210920